

**БАТЛАН ХАМГААЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэх),

Хоёр улсын хооронд тогтсон найрсаг харилцааг харгалзан үзэж,

Батлан хамгаалахын хамтын ажиллагаагаар дамжуулан хоёр улсын одоо байгаа хоёр талт харилцааг улам өргөжүүлж, бэхжүүлэхийг эрмэлзэж,

Тэгш эрх, харилцан ашигтай байх болон Талуудын бүрэн эрхт байдлыг хүндэтгэх зарчимд үндэслэн хоёр улсын батлан хамгаалахын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьж,

Энэхүү Хэлэлцээрийг үндэсний болон олон улсын бодлоготой нийцүүлэн, үндэсний хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бөгөөд олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэгт сөргөөр нөлөөлөхгүй байдлаар хэрэгжүүлэхийг хүсэж,

Дараах асуудлыг харилцан тохиролцов.

**1 дүгээр зүйл
Зорилго**

Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь Талуудын харилцан ашиг сонирхолд нийцүүлэн мэдлэг, туршлага солилцох замаар батлан хамгаалахын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.


**2 дугаар зүйл
Талуудын эрх бүхий байгууллага**

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх Талуудын эрх бүхий байгууллага нь дараах байдалтай байна.

Монгол Улсын хувьд Монгол Улсын Батлан хамгаалах яам;

Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний батлан хамгаалах яам.

2. Хоёрдугаар зүйлийн 1 дэх заалтыг үл харгалзан, энэхүү Хэлэлцээрийн хүрээнд 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан батлан хамгаалахын тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамжийг шилжүүлэх, хүлээн авах, түр хугацаагаар оруулахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Монгол Улсын Батлан хамгаалах яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Батлан хамгаалах худалдан авалтын хөтөлбөрийн захиргаа байна.



3 дугаар зүйл
Батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээ

1. Талууд өөрсдийн үндэсний хууль тогтоомж, дүрэм журам болон бодлогын хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллана:

а) Цэргийн боловсрол, сургалт, спорт, соёлын солилцоо болон мэдээлэл, туршлага солилцох замаар батлан хамгаалах салбарын хоёр талын харилцааг дэмжих;

б) Батлан хамгаалахын анагаах ухаан, шинжлэх ухаан, технологи, судалгаа болон хөгжлийн салбар дахь хамтын ажиллагааг дэмжих;

в) Батлан хамгаалах салбар дахь харилцан тохиролцсон бусад чиглэлийн хамтын ажиллагаа.

2. Энэ зүйлд заасан хамтын ажиллагааны тодорхой арга хэмжээг Талууд харилцан тохиролцож тодорхойлно.

4 дүгээр зүйл
Батлан хамгаалах бодлогын ажлын түвшний уулзалт

Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах, удирдах зорилгоор Талууд батлан хамгаалах бодлогын ажлын түвшний уулзалтыг тогтмол зохион байгуулна. Уулзалтыг Монгол Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсад ээлжлэн зохион байгуулна.

5 дугаар зүйл
Санхүүгийн зохицуулалт

1. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд аливаа арга хэмжээг зохион байгуулахдаа өөрөөр тохиролцоогүй бол айлчлал хийж буй Тал нь хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт байх хугацаандаа өөрсдийн үйл ажиллагааны зардлыг хариуцна.


2. Монгол Улсын Засгийн газар энэхүү Хэлэлцээрийн хүрээнд батлан хамгаалах тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамжийг шилжүүлэх, хүлээн авах түр хугацаагаар оруулахтай холбоотой үйл ажиллагаанд татвар, хураамж ногдуулахгүй.

6 дугаар зүйл
Нууц мэдээллийг хамгаалах

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд нууц мэдээллийг хамгаалах асуудлыг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Сөүл хотноо байгуулсан "Цэргийн нууц мэдээллийг харилцан хамгаалах тухай хэлэлцээр"-ийн дагуу зохицуулна.

7 дугаар зүйл
Маргаан шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргааныг зөвхөн Талууд хоорондын зөвлөлдөх, хэлэлцээ хийх замаар



шийдвэрлэнэ. Маргааныг үндэсний, олон улсын эсхүл гуравдагч талын аль ч шүүхэд шилжүүлэхгүй.

8 дугаар зүйл Төгсгөлийн заалт

1. Энэхүү Хэлэлцээр нь тодорхойгүй хугацаагаар байгуулагдах бөгөөд Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангасан тухай Талуудын сүүлчийн мэдэгдлийг дипломат шугамаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Талууд харилцан бичгээр тохиролцсоны үндсэн дээр Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Ийм нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болно.

3. Аль нэг Тал нөгөө Талд бичгээр мэдэгдэн Хэлэлцээрийг хэзээ ч цуцалж болно. Ийм мэдэгдлийг нөгөө Тал хүлээн авснаас хойш 180 хоногийн дараа Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусгавар болно.

4. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусгавар болох нь Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд нөлөөлөхгүй.

ҮҮНИЙГ НОТОЛЖ, энэхүү Хэлэлцээрт хоёр талын Засгийн газраас албан ёсоор гарын үсэг зурах эрх олгогдсон төлөөлөгчид гарын үсэг зурав.

Улаанбаатар хотноо 2026 оны 7 дугаар сарын-ны өдөр монгол, солонгос болон англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

